



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠦ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/431

Алтай хот

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтай сумд бохир соруулдаг автомашин нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Х.Баатарзориг	-(Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Я.Жаргалцэцэг	-(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн)
	Ё.Нарангарав	-(Төрийн бус байгууллагын төлөөлөл) (тохиролцсон)
	Ц.Батсайхан	-(Есөнбулаг сумын иргэн)
Нарийн бичгийн дарга:	Ц.Анхбаяр	-(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Х.Баатарзориг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ